



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ

АУДИТЫН КОД: ДАА-2025/01/НА-СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авч уу.



**Дарга, төргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**  
Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn  
**Аудитын менежер Ү.Батсүрэн**  
Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn  
**Ахлах аудитор С.Батцэцэг**  
Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn  
**Аудитор Н.Отгонцэцэг**  
Утас: 70373089 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn  
**Аудитор Д.Ариунзаяа**  
Утас: 70373089 Цахим хаяг: ariunzayad@audit.gov.mn  
**Шинжээч Э.Мөнгөнцэцэг**  
Утас: 70373089 Цахим хаяг: mungurtsetsegs@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	2
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ 1. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙГ УЛСЫН БОЛОН АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ УЯЛДУУЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА. ....	6
БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 14,825.4 САЯ ТӨГРӨГӨӨР БУЮУ 22.6 ХУВИАР ДАВЖ БИЕЛСЭН БАЙНА.....	9
<i>2.1. Аймгийн орлогын эх үүсвэрт үндэслэн сангийн яамны хянасан дүнг 3,484.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ .....</i>	<i>9</i>
<i>2.2 Аймгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 109,772.3 сая төгрөгөөр төлөвлөж, 112.8 хувийн гүйцэтгэлтэй байна.....</i>	<i>10</i>
БҮЛЭГ 3: ТӨСВИЙН НИЙТ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ 81,541.3 САЯ ТӨГРӨГ БУЮУ 74.3 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ГАРСАН НЬ ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН 58.4 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛ НӨЛӨӨЛСӨН БАЙНА.....	12
<i>3.1. Төсвийн тодотголоор нийт зарлагыг 28,321.6 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.....</i>	<i>12</i>
<i>3.2 Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлж, нэг удаагийн тэтгэмж олгож эхэлснээр урсгал зардал өнгөрсөн оноос 32,222.6 сая төгрөгөөр өсөхөд голлон нөлөөлжээ</i>	<i>14</i>
БҮЛЭГ 4: АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦЭЛ 42,316.7 САЯ ТӨГРӨГИЙН АШИГТАЙ ГАРСАН БАЙНА.....	18
ДҮГНЭЛТ:.....	19
ЗӨВЛӨМЖ:.....	19
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20
Дархан-Уул аймгийн 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	21
Нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	24

## Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БГАУТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
ГТНАТ	Газрын тосны нөөц ашигласны төлбөр
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УИХ	Улсын Их Хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХК	Хувьцаат компани
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан



### Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Аймгийн төсвийн тэнцлийн судалгаа	5
Хүснэгт №2	Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр	6
Хүснэгт №3	Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан	7
Хүснэгт №4	Орлогын төсвийн төсөл, батлагдсан төсөв	9
Хүснэгт №5	Төсвийн орлогын батлагдсан төлөвлөгөө	9
Хүснэгт №6	Төсвийн орлогын гүйцэтгэл	10
Хүснэгт №7	Тусламж санхүүжилтийн орлогын гүйцэтгэл	11
Хүснэгт №8	Төсвийн зарлагын төлөвлөгөө	12
Хүснэгт №9	ТЕЗ-ийн 2023 оны төсвийн зарлагын батлагдсан төлөвлөгөө	13
Хүснэгт №10	Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
Хүснэгт №11	Урсгал зардлын гүйцэтгэл	15
Хүснэгт №12	Нэмэлт санхүүжилт	16
Хүснэгт №13	Нэгдсэн төсвийн тэнцэл	18

### Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	Төсвийн зарлагын тодотгол	13

**Аудит хийх  
үндэслэл, бүрэн эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн  
талаарх мэдэгдэл**

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

**Аудитын зорилт**

Дархан-Уул аймгийн 2024 оны төсвийг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг үр ашигтай зарцуулж, үнэн зөв тайлагнасан эсэхийг шалгаж, дүгнэлт гарган, аймгийн удирдлагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төсвийн зарлагыг бүсчилсэн хөгжлийн бодлого, богино хугацааны бодлогын баримт бичигт үндэслэн төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх;
- Төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, бүрэн биелүүлсэн эсэх
- Төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан эсэх;

**Аудитын хамарсан  
хүрээ**

Аудитыг Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны батлагдсан төсөв, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, ТЕЗ-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүний хэрэгжилт болон бусад судалгаа, материалд тулгуурлан гүйцэтгэв.

**Аудитын арга зүй,  
шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхдээ гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалд заасан арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр, аудитын менежер У.Батсүрэн нар хянан удирдаж, аудитыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитор З.Мөнгөнцэцэг, Н.Отгонцэцэг, Д.Ариунзаяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

## Ерөнхий мэдээлэл

УИХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Дархан-Уул аймгийн 2024 оны суурь орлогыг 49,021.1 сая төгрөг, зарлагыг 47,665.6 сая төгрөг, аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 1,355.5 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 19,834.2 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Хүснэгт 1. Аймгийн төсвийн тэнцлийн судалгаа (сая төгрөг)

Үзүүлэлт	Сангийн яамны хянасан дүн	2024 он			Гүйцэтгэл
		Анх батлагдсан 2023.11.24 №54	Аймгийн ИТХ-ын 2024.04.06 №07	Аймгийн ИТХ-ын 2024.11.15 №09	
ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар	2023.11.10	2023.11.24 №54	2024.04.26 №07	2024.11.15 №09	
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	68,855.4	81,450.6	90,490.0	109,772.3	123,858.0
<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	49,021.1	52,506.1	52,498.3	65,459.9	80,285.3
Татварын орлого	46,861.0	48,579.7	48,571.9	60,794.7	73,580.8
Татварын бус орлого	2,160.1	3,926.4	3,926.4	4,665.2	6,704.5
<b>Тусламжийн орлого</b>	19,834.2	19,834.2	19,834.2	20,763.5	20,023.7
<b>Өмнөх оны дансны үлдэгдэл</b>	-	9,110.3	18,157.5	23,549.0	23,549.0
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	67,499.9	81,450.6	90,490.0	109,772.3	81,541.3
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	44,154.8	52,053.7	52,697.1	65,061.0	55,994.3
Бараа, ажил үйлчилгээний зардал	39,777.7	39,441.9	40,690.8	46,867.4	39,975.3
Хүү	0.0	-	-	3,600.0	3,600.0
Татаас	3,020.9	4,092.0	4,092.0	4,934.2	4,567.5
Урсгал шилжүүлэг	1,356.2	8,519.8	7,914.3	9,659.4	7,851.5
Хөрөнгийн зардал	23,345.0	28,395.0	36,791.0	43,632.2	25,489.0
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0.0	1,001.9	1,001.9	1,079.2	58.0
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	1,355.5	0.0	0.0	0.0	42,316.7

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор аймгийн 2024 оны төсвийн нийт орлого, зарлагыг 81,450.6 сая төгрөгөөр баталсан нь төсвийн орлогыг 12,595.2 сая төгрөг, зарлагыг 13,950.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Аймгийн төсөвт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, аймгийн ИТХ-ын тогтоолоор урсгал орлогыг 12,953.8 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 14,438.7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих орлогын шилжүүлгийг 929.3 сая төгрөг, төсвийн нийт орлогыг 28,321.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Тайлант онд 2024 оны нийт орлогыг 109,772.3 сая төгрөгөөр төлөвлөж, 123,858.0 сая төгрөг буюу 112.8 хувиар биелсэн байна. Харин урсгал орлогыг 65,459.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 80,285.3 сая төгрөг буюу 122.6 хувиар давж биелжээ.

Гүйцэтгэлээр төлөвлөсөн орлого 112.8 хувиар биелсэн нь урсгал орлого төлөвлөснөөс 14,135.7 сая төгрөгөөр буюу 22.6 хувиар давж биелснээс шалтгаалжээ.

Аймгийн төсвийн нийт зарлагыг 109,772.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр урсгал зардалд 55,994.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 25,489.0 сая төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 58.0 сая төгрөг, нийт 81,541.3 сая төгрөг зарцуулж, 74.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

## БҮЛЭГ 1. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙГ УЛСЫН БОЛОН АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ УЯЛДУУЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1.1 Дархан-Уул аймгийн 2024 оны төсвийг боловсруулахдаа УИХ, Засгийн газрын баримталсан 2024 оны төсвийн бодлогын онцлог 10 арга хэмжээ, “Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Аймгийг 2024 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө” зэрэг дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг чиглэл болгожээ.

1.1.2 Дархан-Уул аймаг нь бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөрөнгө оруулалтыг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх 3 зорилт, 12 арга хэмжээг, Дархан-Уул аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 10 арга хэмжээг тус тус тусгаж баталсан байна.

1.1.3 Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2023 оны 44 дүгээр тогтоолоор “Дархан-Уул аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд ТЕЗ-ын хэрэгжүүлэх 108 төсөл, арга хэмжээг 710,074.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Хүснэгт 2. Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр

(сая. төгрөг)

Эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөв
Орон нутгийн төсөв	48	5,580.6
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	34	300,165.7
Гадаадын зээл тусламж, төсөл	14	13,959.8
ХЭДС, ХХСан, ЖДҮХС	4	274.0
Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	1	240,000.0
Бусад	7	150,093.9
<b>Нийт</b>	<b>108</b>	<b>710,074.0</b>

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2023 оны 44 дүгээр тогтоол

1.1.5 Аймгийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээнээс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 48 төсөл, арга хэмжээг 5,580.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан нь нийт санхүүжилтийн 0.8 хувь байна.

1.6 Орон нутгийн төсөв нь “Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалттай<sup>1</sup> байхад дараах 3 зорилт, арга хэмжээг аймгийн 2024 оны төсөвт тусгаж батлаагүй. Үүнд:

- Орхон, Хонгор сумдын төвийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг үе шаттай хангах
- Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд хамгаалалтын хайс барьж тохижуулах
- Гадаргын усны чанарын шинжилгээний болон хэмжилтийн явуулын багаж, тоног төхөөрөмж авах зэрэг арга хэмжээг төлөвлөөгүй байна.

## 1.2 Дархан-Уул аймгийг хөгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутгийн төсвөөр хэрэгжих зарим арга хэмжээ хэрэгжээгүй тул 86.6 хувиар үнэлсэн байна.

1.2.1 Аймгийн 2024 оны төсөвт “Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний 48 арга, хэмжээг санхүүжүүлэхээр 5,580.6 сая төгрөг баталснаас, дараах 5 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

<sup>1</sup> Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4 орон нутгийн төсөв нь Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх

- “Аймгийн төвд байрлах “Залуучууд театр”-н Лэд дэлгэцээр иргэдэд мэдээлэл түгээх” ажлын гүйцэтгэл 0 хувь,
- “Гадаргын усны чанарын шинжилгээний болон хэмжилтийн явуулын багаж, тоног төхөөрөмж авах” ажлын гүйцэтгэл 0 хувь,
- “Орхон, Хонгор сумдын төвийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг үе шаттай хангах” ажлын гүйцэтгэл 30 хувь,
- “Галт түймэр унтраах 54 дүгээр анги, 8 дугаар цэцэрлэгийг төвийн төвлөрсөн шугамд холбох” ажлын гүйцэтгэл 30 хувь,
- “Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд хамгаалалтын хайс барьж тохижуулах” ажлын гүйцэтгэлийг 30 хувиар тус тус Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс үнэлсэн байна.

1.2.2 Аймгийн ИТХ-ын 2024 оны 9 дүгээр тогтоолоор ТЕЗ-ийн 30 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 109,772.3 сая төгрөг зарцуулахаар баталж, гүйцэтгэл 74.3 хувьтай гарсан байна.

Хүснэгт 3. Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан (сая. төгрөг)

№	Хөтөлбөр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	70105 ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	3,226.1	3,127.6	(98.5)	96.9
2	70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	43,181.9	28,368.9	(14,813.0)	65.7
3	70207 Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх арга хэмжээ	3,600.0	3,600.0	-	100.0
4	70418 Худалдан авах ажиллагаа	404.5	378.2	(26.3)	93.5
5	70425 Орон нутгийн хэвлэл мэдээлэл	523.1	402.6	(120.5)	
6	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	4,286.8	1,841.1	(2,445.7)	42.9
7	70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	594.6	549.0	(45.5)	92.3
8	70501 ОН-ын төсөвт олгох орлогын шилжүүлэг	25,360.5	19,217.3	(6,143.2)	75.8
9	70704 Цагдаа	33.8	30.6	(3.2)	90.6
10	70708 Гамшгаас урьдчилан сэргийлэх,	100.0	100.0	-	100.0
11	70709 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	897.1	880.2	(16.9)	98.1
12	70805 Хөдөө аж ахуйн газрын бодлого	174.8	157.8	(17.0)	90.3
13	71101 Авто зам	3,130.7	1,215.2	(1,915.5)	38.8
14	71401 Хог хаягдал	7,000.5	7,000.5	-	100.0
15	71403 Ойжуулалт	145.1	121.5	(23.6)	83.7
16	71413 Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх	1,362.1	1,189.6	(172.5)	87.3
17	71502 Хот байгуулалт, тохижилт	1,000.0	1,000.0	-	100.0
18	71506 Суурин газрын усан хангамж	758.3	758.3	-	100.0
19	71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	1,412.6	1,243.0	(169.6)	88.0
20	71701 Биеийн тамир спорт	923.0	199.1	(723.9)	21.6
21	71702 Соёл урлаг	525.9	456.4	(69.5)	86.7
22	71801 Сургуулийн өмнөх боловсрол	2,272.1	1,836.4	(435.7)	80.8
23	71802 Ерөнхий боловсрол	2,987.7	2,587.2	(400.5)	86.6
24	71804 Мэргэжлийн боловсрол	776.4	543.5	(232.9)	70.0
25	71902 Нийгмийн халамж	220.6	198.7	(21.9)	90.0
26	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	387.5	314.9	(72.6)	81.2
27	72206 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгаалал	612.2	561.2	(51.0)	91.7
28	72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал	933.3	896.1	(37.2)	96.0
29	72208 Ахмад настны хөгжил хамгаалал	2,779.6	2,610.1	(169.5)	93.9
30	72212 Гэр бүлийн хөгжил, хамгаалал	161.1	157.0	(4.1)	97.4
<b>Нийт дүн</b>		<b>109,772.3</b>	<b>81,542.3</b>	<b>28,230.0</b>	<b>74.3</b>

1.2.3 Хөрөнгө оруулалтын 30 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй, 13 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэнээс “ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага”, “ОН-ын төсөвт олгох орлогын шилжүүлэг”, “Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх”, “Авто зам” зэрэг хөтөлбөрүүд 40-75%-ийн гүйцэтгэлтэй гарчээ.

1.2.4 Харин “Биеийн тамир спорт” хөтөлбөр нь УИХ-ын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн тогтоолоор аймгийн суурь зарлагын төсөвт “Дархан Арена спорт цогцолбор”-ын тогтмол зардалд 500.0 сая төгрөг баталсан, спорт цогцолбор 2024 оны 9 дүгээр сард барилга ашиглалтад орсон зэргээс шалтгаалжээ.

Мөн “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөр 70 хувийн хэрэгжилттэй байгаа нь цэвэр бохир ус, цахилгааны үнэ 30-40 хувиар өссөнөөр төсвийн суурь зарлага нэмж баталсан болон гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байв.



## БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 14,825.4 САЯ ТӨГРӨГӨӨР БУЮУ 22.6 ХУВИАР ДАВЖ БИЕЛСЭН БАЙНА

### 2.1. Аймгийн орлогын эх үүсвэрт үндэслэн сангийн яамны хянасан дүнг 3,484.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ

2.1.1 Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйл 57.2, 57.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, өмнөх оны гүйцэтгэл, орон нутгийн ТЕЗ-ийн 2024 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжийн дагуу харьяа байгууллагуудаас ирүүлсэн тооцоололд үндэслэн нийт 36,730.5 сая төгрөгийн орлогын саналыг хуулийн хугацаанд Монгол Улсын Сангийн яаманд хүргүүлжээ.

2.1.2 Хүргүүлсэн орлогын саналыг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр баталсан хуулиар Дархан-Уул аймгийн нийт орлогыг 12,290.6 сая төгрөгөөр буюу 33.4 хувиар нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 19,834.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт 4. Орлогын төсвийн төсөл, батлагдсан төсөв (сая төгрөг)

№	Үзүүлэлт	Төсвийн төсөл	Сангийн яамны хянасан /2023.11.13/	ИТХ-ын баталсан төсөв /2023.11.24/	Өөрчлөлт	
					Төсвийн төслөөс	УИХ-аас
	<b>Төсвийн суурь орлого</b>	36,730.5	49,021.1	52,506.0	15,775.5	3,484.9
1	<b>Татварын орлого</b>	35,223.0	46,861.0	48,579.7	13,356.7	1,718.7
1.1	ХХОАТатвар	31,476.0	39,321.0	40,233.0	8,757.0	912.0
1.2	ХХОАТ-ын буцаалт	(3,300.0)	(3,300.0)	(3,300.0)	-	-
1.3	ААНОАТатвар	700.0	3,600.0	3,600.0	2,900.0	-
1.4	Хөрөнгийн албан татвар	2,621.3	3,120.0	3,662.9	1,041.6	542.9
1.5	Бусад татвар /төлбөр хураамж/	3,725.7	4,120.0	4,383.8	658.1	263.8
2	<b>Татварын бус орлого</b>	1,507.5	2,160.1	3,926.3	2,418.8	1,766.2
2.1	Хүү, торгуулийн орлого	1,010.0	1,300.0	1,685.0	675.0	385.0
2.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	210.1	568.4	568.4	358.3
2.3	Бусад орлого	497.5	650.0	892.5	395.0	242.5
2.4	Хоршоог хөгжүүлэх сангийн орлого			780.4	780.4	780.4

2.1.3 Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2023 оны 54 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг батлахдаа Сангийн яамны хянасан дүнгээс 3,484.9 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Энэ нь газрын төлбөрийн орлого 194.4 сая төгрөгөөр, хөрөнгийн албан татварыг 542.9 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 358.3 сая төгрөгөөр, Хоршоог хөгжүүлэх сангийн орлогыг 780.4 сая төгрөгөөр тус тус өсгөж баталснаас шалтгаалжээ. Мөн урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 9,110.4 сая төгрөгөөр баталжээ.

Төсвийн тодотголоор орлогыг 12,953.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна

2.1.4 Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр тогтоолоор баталсан тодотголд орон нутгийн төсвийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 15,175.7 сая төгрөгөөр, анх баталсан төсвөөс 12,953.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 5. Төсвийн орлогын батлагдсан төлөвлөгөө (сая төгрөг)

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Анх баталсан төсөв /2023.11.24/ №54	2024.04.06	2024.11.15
				№07 тогтоолоор	№09 тогтоолоор
	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	50,284.1	52,505.9	52,498.1	65,459.8
1	<b>Татварын орлого</b>	44,732.1	48,579.7	48,571.9	60,794.6
1.1	ХХОАТатвар	36,547.9	40,233.0	40,233.0	50,555.9
1.2	ХХОАТ-ын буцаалт	(2,558.6)	(3,300.0)	(3,350.0)	(3,350.0)

1.3	ААНОАТатвар	87.9	3,600.0	3,600.0	5,000.0
1.4	Хөрөнгийн албан татвар	3,853.7	3,663.0	3,705.2	3,599.1
1.5	Бусад татвар /төлбөр хураамж/	6,801.2	4,383.7	4,383.7	4,989.6
2	<b>Татварын бус орлого</b>	<b>5,552.0</b>	<b>3,926.2</b>	<b>3,926.2</b>	<b>4,665.2</b>
2.1	Хүү, торгуулийн орлого	2,995.1	1,685.0	1,685.0	2,165.0
2.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	574.5	568.3	568.3	772.3
2.3	Бусад орлого	1,285.0	892.5	892.5	947.5
2.4	Хоршоог хөгжүүлэх сангийн орлого	697.4	780.4	780.4	780.4

2.1.5 Төсвийг нэмж тодотгосон нь Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг 04 дүгээр сарын 01-ны өдрөөс нэмэгдүүлсэн, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор төрийн захиргааны болон улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 20-40 хувиар олгож эхэлснээр цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 3,993.9 сая төгрөгөөр, ААНОАТ-ыг гүйцэтгэлд үндэслэн 1,400.0 сая төгрөгөөр, бусад орлогын татварыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн иргэдэд олгосон ногдол ашгийн дүнгээс 3,957.0 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогыг орон сууцны борлуулалт нэмэгдсэнтэй холбогдуулан 1,608.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

## 2.2 Аймгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 109,772.3 сая төгрөгөөр төлөвлөж, 112.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.1 Дархан-Уул аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн суурь орлого 80,285.3 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 14,825.4 сая төгрөгөөр, өмнөх оноос 30,001.3 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Хүснэгт 6. Төсвийн орлогын гүйцэтгэл

(сая төгрөг)

Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 он				Өмнөх оны зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
<b>Татварын орлого</b>	<b>44,732.0</b>	<b>60,794.7</b>	<b>73,580.7</b>	<b>12,786.0</b>	<b>121.0</b>	<b>28,848.7</b>
ХХОАТ	36,547.8	50,555.9	57,483.7	6,927.8	113.7	20,935.9
ХХОАТ-ын буцаалт	(2,558.6)	(3,350.0)	(3,346.0)	4.0	99.9	(787.4)
ААН-ын орлогын албан татвар	87.9	5,000.0	8,329.2	3,329.2	166.6	8,241.3
Хөрөнгийн албан татвар	3,853.7	3,599.2	4,060.3	461.1	112.8	206.6
Бусад татвар	6,801.2	4,989.6	7,053.5	2,063.9	141.4	252.3
<b>Татварын бус орлого</b>	<b>5,552.0</b>	<b>4,665.2</b>	<b>6,704.6</b>	<b>2,039.4</b>	<b>143.7</b>	<b>1,152.6</b>
Хүү, торгуулийн орлого	2,995.1	2,165.0	4,051.0	1,886.0	187.1	1,055.9
Төсвийн байгууллагын өөрийн орлого	574.5	772.3	741.0	(31.3)	95.9	166.5
Бусад орлого	1,285.0	947.5	1,376.2	428.7	145.2	91.2
Хоршоог хөгжүүлэх сангийн орлого	697.4	780.4	536.4	(244.0)	68.7	(161.0)
<b>Нийт дүн</b>	<b>50,284.0</b>	<b>65,459.9</b>	<b>80,285.3</b>	<b>14,825.4</b>	<b>122.6</b>	<b>30,001.3</b>

2.2.2 Засгийн газрын 2024 оны 82, 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн доод хэмжээ нэмэгдсэн, орон нутгийн нэмэгдлийг төрийн захиргааны болон улс төрийн албан хаагчдад олгож эхэлсэн, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан урамшууллыг төрийн захиргааны албан хаагчдад олгосон зэргээс шалтгаалан цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 13,179.7 сая төгрөг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашиг олгосноор бусад татвар хураамж 5,504.4 сая төгрөгөөр, ААНОАТ-ын орлого 5,504.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь төсвийн орлого өмнөх оноос 30,001.3 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

2.2.3 Төсвийн орлогын гүйцэтгэлийн 91.6 хувийг татварын орлого, 8.4 хувийг татварын бус орлого эзэлж байна. Аймгийн татварын орлого 73,580.7 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс

12,786.0 сая төгрөгөөр буюу 21 хувиар, татварын бус орлого 6,704.6 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 2,039.4 сая төгрөгөөр буюу 43.7 хувиар тус тус давж биелсэн байна.

2.2.4 Аймгийн татварын орлого 12,786.0 сая төгрөгөөр давж биелэхэд дараах хүчин зүйл нөлөөсөн байна. Үүнд:

- “Дархан Төмөрлөгийн Үйлдвэр” ТӨХК оны эцэст албан хаагчдад 13 дахь сарын цалин хөлс олгосноор Хонгор сумын орлого 793.8 сая төгрөгөөр, өмнөх оны татварын өрийн үлдэгдэл төвлөрснөөр Дархан сумын орлого 3,455.7 сая төгрөгөөр тус тус давж биелснээр цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын 4,966.6 сая төгрөгөөр,
- Арилжааны банкны хадгаламжийн хүүгийн орлого өссөнөөр иргэдийн хадгаламж нэмэгдэж хадгаламжийн хүүгийн орлого 660.2 сая төгрөгөөр, “Эрдэнэс Тавантолгой” ХК иргэдэд ногдол ашиг олгогдсоноор бусад орлого 1,067.4 сая төгрөгөөр тус тус давж биелсэн тул ХХОАТ-ын орлого 6,927.7 сая төгрөгөөр,
- Тайлант оны эцэст дуудлага худалдааны орлого 1,212.8 сая төгрөгөөр, ААНОАТ-ын 3,329.2 сая төгрөгөөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 758.6 сая төгрөгөөр тус тус төвлөрснөөр бусад татварын орлого 12,786.1 сая төгрөгөөр давж биелэхэд нөлөөлжээ.

2.2.5 Татварын бус орлого төлөвлөснөөс 43.7 хувиар буюу 2,063.9 сая төгрөгөөр давж биелэхэд “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ оны эцэст ашгаас ногдол ашиг төвлөрүүлснээр 84.6 сая төгрөгөөр, орон нутгийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон авто тээврийн зөрчлийн тоо, хяналт, шалгалтын байгууллагын тогтоосон актын төлбөрийн барагдуулалтаас шалтгаалж, аймгийн хүү, торгуулийн орлого 1,886.0 сая төгрөгөөр тус тус давсан нь нөлөөлжээ.

*Тусламж, санхүүжилтийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна*

2.2.6 Тайлант онд төлөвлөсөн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 20,023.7 сая төгрөг, урьд оны үлдэгдэл 23,549.0 сая төгрөг, нийт 43,572.7 сая төгрөгийн санхүүжилтийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 7. Тусламж, санхүүжилтийн орлогын гүйцэтгэл (сая төгрөг)

Орлогын нэр төрөл	2023 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	2024 он			Өмнөх оны зөрүү
			Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
ОНХС-ийн орлогын шилжүүлэг	13,362.7	20,763.5	20,023.7	(739.8)	96.4	14,102.5
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	11,918.7	23,549.0	23,549.0	-	100.0	(11,630.3)
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>25,281.4</b>	<b>44,312.5</b>	<b>43,572.7</b>	(739.8)	<b>98.2</b>	<b>25,732.8</b>

2.2.7 Аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэгт ГТНАТ-ын орлогоос 30 хувь буюу 300.1 сая төгрөг, АМНАТ-ын 10 хувь буюу 17,796.6 сая төгрөг, улсын төсвөөс 66.4 сая төгрөг, сумдын ОНХС-д олгох гүйцэтгэлийн урамшуулал 1,671.1 сая төгрөг, нийт 19,834.2 сая төгрөг хуваарилсан байна. ОНХС-ийн нэгдсэн сангаас олгосон санхүүжилт 96.4 хувьтай байгаа нь 20,023.7 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосонтой холбоотой байна.

### БҮЛЭГ 3: ТӨСВИЙН НИЙТ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ 81,541.3 САЯ ТӨГРӨГ БУУУ 74.3 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ГАРСАН НЬ ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН 58.4 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛ НӨЛӨӨЛСӨН БАЙНА

#### 3.1. Төсвийн тодотголоор нийт зарлагыг 28,321.6 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Аймгийн төсвийн урсгал зардлыг сангийн яамны хянасан дүнгээс 7,898.8 сая төгрөгөөр нэмж баталжээ

3.1.1 Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж чиглэл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын хүрээнд боловсруулсан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн суурь зардлын 49,204.0 сая төгрөгийн төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн хуралдаанаар 1,538.4 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар бууруулж баталсан нь урсгал зардлыг 12,262.1 төгрөгөөр нэмэгдүүлж, хөрөнгийн зардлыг 11,083.7 сая төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

3.1.2 Мөн Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Дархан-Уул аймгийн төсвийн суурь зарлагыг 67,499.9 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 658.2 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Хүснэгт 8. ТЕЗ-ийн 2024 оны төсвийн зарлагын төлөвлөгөө (сая төгрөг)

Үзүүлэлт	Төсвийн төсөл	Сангийн яамны хянасан	ИТХ-ын баталсан төсөв	Өөрчлөлт	
				Төсвийн төслөөс	Сангийн яамны баталснаас
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>49,204.0</b>	<b>67,499.9</b>	<b>81,450.5</b>	<b>(1,538.4)</b>	<b>13,950.6</b>
<b>А. УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>31,892.7</b>	<b>44,154.9</b>	<b>52,053.6</b>	<b>12,262.1</b>	<b>7,898.7</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,221.5	39,777.9	39,441.8	11,556.2	(336.1)
ХҮҮ		-	-	-	-
ТАТААС	2,393.5	3,020.9	4,091.9	627.4	1,071.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,277.7	1,356.1	8,519.7	78.4	7,163.6
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>17,311.3</b>	<b>23,345.0</b>	<b>28,395.0</b>	<b>(11,083.7)</b>	<b>5,050.0</b>
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1,001.9</b>	<b>-</b>	<b>1,001.9</b>

3.1.3 Аймаг, сумдын ИТХ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвийн зарлагыг Монгол Улсын Их Хурлын баталсан дүнгээс 13,950.6 сая төгрөгөөр нэмж баталсан нь дараах зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Үүнд:

- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн доод хэмжээг нэмэгдүүлсэн, 2024 оны 82 дугаар тогтоолоор төрийн захиргааны болон улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгож эхэлсэн зэргээс шалтгаалж, цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3,471.0 сая төгрөгөөр,
- ✓ "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээ, урсгал засвар, тавилга эд хогшил зардлыг 778.5 сая төгрөгөөр,
- ✓ Аймаг, сумдын ИТХ-д суудалтай намд олгох санхүүгийн дэмжлэгийг 904.5 сая төгрөгөөр,
- ✓ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн зардлыг 10,560.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

3.1.4 Аймгийн ИТХ-ын 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 7 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1.а, 42.2.1 дэх заалтуудыг үндэслэн нийт 9,039.4 сая төгрөгийн дараах зардлуудыг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр нэмж баталсан байна. Үүнд:

- Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд 114.3 сая төгрөг,
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардалд 8,395.9 сая төгрөг,
- Нэгдсэн эмнэлгийн тогтмол зардалд 732.7 сая төгрөг,
- Орхон, Хонгор сумын хоршоог хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 569.3 сая төгрөг,
- Дархан-Уул аймгийн Засаг даргын нөөц санг 295.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Төсвийн тодотголоор зарлагыг 19,282.4 сая төгрөгөөр нэмж баталжээ.

3.1.5 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр аймгийн төсвийн суурь зарлагыг 1,857.0 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 696.9 сая төгрөгөөр, ОНХС-ийн нэгдсэн сангаас зарцуулах зарлагыг 929.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон байна.

Дүрслэл 1. Төсвийн зарлагын тодотгол /сая төгрөг/



3.1.6 Аймгийн ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1<sup>2</sup> дэх заалтын дагуу орон нутгийн орлогын эх үүсвэрт үндэслэн тодотгол хийж, төсвийн зарлагыг 19,282.4 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Хүснэгт 9. ТЕЗ-ийн 2024 оны төсвийн зарлагын батлагдсан төлөвлөгөө (сая төгрөг)

Үзүүлэлт	Анх батлагдсан (2023.11.24)	Аймгийн ИТХ-ын 7 дугаар тогтоол (2024.04.26)	Төсвийн тодотгол (2024.11.15)	Өөрчлөлт	
				Аймгийн ИТХ-ын тогтоол	Төсвийн тодотгол
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>81,450.5</b>	<b>90,489.9</b>	<b>109,772.3</b>	<b>9,039.4</b>	<b>19,282.4</b>
<b>А. УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>52,053.6</b>	<b>52,697.0</b>	<b>65,060.9</b>	<b>643.4</b>	<b>12,363.9</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,441.9	40,690.8	46,867.4	1,248.9	6,176.6
ХҮҮ	-	-	3,600.0	-	3,600.0
ТАТААС	4,091.9	4,091.9	4,934.2	-	842.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,519.8	7,914.3	9,659.4	(605.5)	1,745.1
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>28,395.0</b>	<b>36,791.0</b>	<b>43,632.2</b>	<b>8,396.0</b>	<b>6,841.2</b>
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>1,001.9</b>	<b>1,001.9</b>	<b>1,079.2</b>	-	<b>77.3</b>

3.1.7 Энэ нь Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2022 оны 510, 518, 2024 оны 632 дугаар тогтоолоор гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, дулааны үнийг 20-40 хувиар нэмэгдүүлснээр байр ашиглалтын тогтмол зардалд 325.5 сая төгрөгөөр, төрийн байгууллагын хэвийн үйл

<sup>2</sup> Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон

ажиллагааг хангахтай холбоотойгоор эд хогшил, урсгал засварт 1,417.3 сая төгрөгөөр, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 2,640.7 сая төгрөгөөр, Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ болон хот тохижилтын зардалд 1,567.0 сая төгрөгөөр, МУЗГ, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Дархан хотын бохир усны менежментийн сайжруулах зээлийн төсөл”-ийн зээлийн гэрээний хугацаа хэтэрсэн өр төлбөрт 3,600.0 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтад 6,841.2 сая төгрөг тус тус нэмж баталсантай холбоотой байна.

### 3.2 Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлж, нэг удаагийн тэтгэмж олгож эхэлснээр урсгал зардал өнгөрсөн оноос 32,222.6 сая төгрөгөөр өсөхөд голлон нөлөөлжээ

3.2.1 Батлагдсан урсгал зардлын 86.1 хувийн гүйцэтгэлтэй гарч, 9,066.6 сая төгрөг дутуу зарцуулсан нь Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2022 оны 510, 518, 2024 оны 632 дугаар тогтоолыг баримталж байр ашиглалттай холбоотой зардлыг 20-40 хувиар нэмэгдүүлж төлөвлөснөөс 2,535.9 сая төгрөг, замын сангийн хөрөнгө оруулалт хэрэгжээгүйгээс БГАУТХ 2,008.8 сая төгрөг, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид олгох санхүүжилтийн дэмжлэгийг бууруулснаар засгийн газрын урсгал шилжүүлэг 1,672.2 сая төгрөг тус тус зарцуулаагүй нь голлон нөлөөлжээ.

3.2.2 Аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд 109,773.3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 81,541.3 сая төгрөг зарцуулсан нь аймгийн ДНБ-ий 13.0 хувьтай тэнцэж байна. Нийт зардлын гүйцэтгэл 74.3 хувьтай гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 29,410.1 сая төгрөгөөр өссөн байна.

3.2.3 Гүйцэтгэлээр аймгийн ИТХ-ын 2024 оны 9 дүгээр тогтоолын дагуу Дархан сумаас 33,073.8 сая төгрөг, Хонгор сумаас 5,187.6 сая төгрөгийг тус тус аймгийн төсөвт төвлөрч, Орхон суманд 1,386.0 сая төгрөг, Шарын гол суманд 506.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Мөн Монгол Улсын Их хурлын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр баталсан хуульд заасны дагуу аймгийн төсвөөс улсын төсөвт 1,355.1 сая төгрөгийг 100 хувь төвлөрүүлжээ.

Хүснэгт 10. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(сая төгрөг)

Үзүүлэлт	2023 он		2024 он		
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>52,131.2</b>	<b>109,772.3</b>	<b>81,541.3</b>	<b>74.3</b>	<b>28,231.0</b>
<b>А. УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32,838.3</b>	<b>65,060.9</b>	<b>55,994.3</b>	<b>86.1</b>	<b>9,066.6</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,051.8	46,867.3	39,975.3	85.3	6,892.0
ХҮҮ	-	3,600.0	3,600.0	100.0	-
ТАТААС	1,760.1	4,934.2	4,567.5	92.6	366.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,026.5	9,659.4	7,851.5	81.3	1,807.9
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>18,454.1</b>	<b>43,632.2</b>	<b>25,488.9</b>	<b>58.4</b>	<b>18,143.2</b>
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>838.8</b>	<b>1,079.2</b>	<b>58.0</b>	<b>5.4</b>	<b>1,021.2</b>

3.2.4 Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн доод хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 7,349.1 сая төгрөгөөр, Төрийн албаны тухай хуульд орсон өөрчлөлтөөр орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг 2024 оноос олгож эхэлснээр урсгал шилжүүлэг 3,825.0 сая төгрөгөөр тус тус өссөн нь урсгал зардал өнгөрсөн оноос 32,222.6 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

3.2.5 Орон нутгийн төсвийн урсгал зардал орлогын эх үүсвэр нэмэгдсэнээр өмнөх оноос 23,156.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 7,034.8 сая төгрөгөөр тус тус өссөн бол, Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн журам шинэчлэгдсэнээр зарцуулалт 780.8 сая төгрөгөөр буурсан байна.

3.2.6 Аймгийн нийт зарлагын гүйцэтгэлийн 68.7 хувь нь урсгал зардал, 31.2 хувь нь хөрөнгийн зардал, 0.1 хувь нь эргэн төлөгдөх зээл буюу Хоршоог хөгжүүлэх сангийн зээл эзэлж байна.

3.2.7 Аймаг, сумдын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс 904.4 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-т “энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах”; 34 дүгээр зүйлийн 34.6-д “нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно”, 34.6.3-т “төрийн байгууллага болон нутгийн өөрөөр удирдах байгууллага” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Хүснэгт 11. Урсгал зардлын гүйцэтгэл

(сая төгрөг)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>65,060.9</b>	<b>55,994.3</b>	<b>86.1</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ</b>	<b>46,867.3</b>	<b>39,975.3</b>	<b>85.3</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,894.8	13,009.4	93.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,750.1	1,552.2	88.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,171.6	6,635.7	72.4
Хангамж, бараа материалын зардал	560.2	540.0	96.4
Нормативт зардал	144.5	140.2	97.0
Эд хогшил, урсгал засварын зардал	2,856.2	2,711.9	94.9
Томилолт, зочны зардал	188.3	173.3	92.1
Бусдаар гүйцэтгүүлсэн АҮТХ	10,904.8	8,896.1	81.6
Бараа үйлчилгээний бусад зардал	7,396.6	6,316.4	85.4

3.2.8 Бараа үйлчилгээний бусад зардлаас байр ашиглалтын зардал 2,535.9 сая төгрөгөөр буюу 27.6 хувиар, хангамж, бараа материалын зардал 20.2 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар, нормативт зардал 4.3 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 144.3 сая төгрөгөөр буюу 5.1 хувиар, томилолт зочны зардал 15.0 сая төгрөгөөр буюу 7.9 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 2,008.8 сая төгрөг буюу 18.4 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 1,080.2 сая төгрөг буюу 14.6 хувиар тус тус дутуу зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд санхүүжилтийг гүйцэтгэлээр хянах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахад хяналт тавьж ажилласантай холбоотой байна.

3.2.9 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан нийт 41.5 сая төгрөгийн 20 зөрчил илэрснээс төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 22.8 сая төгрөгийн 12 төлбөрийн акт тогтоож, 11.7 сая төгрөгийн зөрчил арилгуулах 3 албан шаардлага, 7.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2.10 Аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийг 1,438.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс 87.0 хувь буюу 1,252.8 сая төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-тай нийцсэн байна.

*Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл:*

3.2.11 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн төсвийн ангилалд баталсан сумдын хоршоог хөгжүүлэх сангаас нийт 1,079.2 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2 аж ахуйн, нэгжид 58.0 сая төгрөгийн зээл олгож гүйцэтгэл 5.3 хувьтай гарсан нь Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/521 дүгээр тушаалаар зөвхөн хоршоодод зээл олгохоор нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотой байна.

3.2.12 Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 573,1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 528.2 сая төгрөг төлөгдсөнөөр 92.1 хувийн биелэлттэй байна.

3.2.13 Сумдын ХХС-ийн 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,411.7 сая төгрөгийн авлагаас 24 иргэн, 2 ААНБ-ын нийт 157.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд олон жил болсон 161.1 сая төгрөгийн 29 зээлдэгчийн авлагыг хуулийн байгууллагад шилжүүлжээ.

*Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.*

3.2.14 Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсвийн байгууллагуудын нэмэлт төсвийн гүйцэтгэлийг аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэсэн байна.

3.2.15 Тайлант онд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 423.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,828.7 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 9.9 сая төгрөг, нийт 2,261.6 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдсэн байна.

*Хүснэгт 12. Нэмэлт санхүүжилт (сая төгрөг)*

№	ТЕЗ-ийн ангилал	Санхүүжилт	Зарцуулалт	Үлдэгдэл
1	Аймгийн ТЕЗ	2,140.4	1,598.6	541.8
2	Дархан сум ТЕЗ	35.0	35.0	0
3	Хонгор сумын ТЕЗ	46.0	45.9	0.1
4	Орхон сумын ТЕЗ	15.2	15.2	0
5	Шарын гол сумын ТЕЗ	25.0	25.0	0.03
Нийт		<b>2,261.6</b>	<b>1,719.7</b>	<b>541.9</b>

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр төвлөрсөн орлогоос урсгал зардалд 1,275.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 444.2 сая төгрөгийг тус тус зарцуулж, 541.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.2.16 Нэмэлт санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйл, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын хүрээнд зарцуулсан байна.

3.2.17 Аймгийн ТЕЗ-ийн нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдэл нь иргэдийн оролцоотой дээврийн болон инженерийн шугам сүлжээний төсөл хөтөлбөрийн үлдэгдэл 79.0 сая төгрөг, цас мөс хайлуулах бодисын санхүүжилтийн үлдэгдэл 45.8 сая төгрөг, Дархан-Улаанбаатар хотын замын трассын нөхөн төлбөрийн үлдэгдэл 170.5 сая төгрөг, Шарын гол сумын соёлын төвийн өргөтгөлийн засварын үлдэгдэл 6.6 сая төгрөг, 2 төсөл арга хэмжээний бэлтгэл ажлын үлдэгдэл 60.3 сая төгрөг, Хүнс хөдөө аж ахуйн яамны засвар үйлчилгээ, тохижилтын үлдэгдэл 406.2 сая төгрөгийг тус тус зарцуулаагүйтэй холбоотой байна.

*Шилэн дансны хуулийн хэрэгжилт:*

3.2.18 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

3.2.19 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудаас 15 байгууллага шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг оруулаагүй, хугацаа хоцроосон нийт 11,632.9 сая төгрөгийн зөрчил илэрчээ. Үүнээс 2 байгууллагын 80.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 13 байгууллагын 11,552.6 сая төгрөгийн зөрчилд цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

*Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт:*

3.2.20 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3, 15.1.4, 15.2.6, нийт 15.4 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 5.5 сая төгрөгийн 3 төлбөрийн акт ( Дархан-уул аймгийн Засаг даргын тамгын газар, Орхон сумын Засаг даргын тамгын газар), 7.3 сая төгрөгийн 2 албан шаардлага ( Шарын гол сумын Засаг даргын тамгын газар, Хонгор сумын Засаг даргын тамгын газар) 2.6 сая төгрөгийн 1 зөвлөмж ( Орхон сумын Засаг даргын тамгын газар)-ийг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

3.2.21 “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитаар 0.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт (Дархан-Уул аймгийн Захирагчийн алба, Орхон сумын ИТХ), 5.0 сая төгрөгийн 1 албан шаардлага (Хонгор сумын ЗДТГ)-ийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүйгээс хөрөнгийн зардал 58.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна

3.2.22 Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 43,632.2 сая төгрөгийн хөрөнгийн зардал төлөвлөснөөс гүйцэтгэлээр 25,488.9 сая төгрөг зарцуулж гүйцэтгэл 58.4 хувьтай гарчээ.

3.2.23 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр төлөвлөсөн 24,051.2 сая төгрөгийн 233 төсөл, арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 8,656.3 сая төгрөгийн 187, дутуу хэрэгжсэн 621.8 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээнд нийт 9,278.1 сая төгрөг зарцуулсан байна. Харин 972.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээ оролцогч ирээгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.

3.2.24 Аймгийн ИТХ-ын 2024 оны 9 дүгээр тогтоолоор 5,420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээг нэмэгдүүлснээр өмнөх оноос шилжиж ирсэн 111, шинээр 30 төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн нийт 14,466.5 сая төгрөгөөс бүрэн хэрэгжсэн 1,041.2 сая төгрөгийн 57, дутуу хэрэгжсэн 4,773.9 сая төгрөгийн 57 төсөл арга хэмжээний санхүүжилтэд нийт 5,815.1 сая төгрөг зарцуулжээ.

3.1.25 Мөн орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,985.5 сая төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 1 төсөл, арга хэмжээнд 178.0 сая төгрөг зарцуулж 11.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь 1,807.5 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгараагүй тул хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

3.1.26 Аймгийн төсвийн нийт гүйцэтгэл 81,541.3 сая төгрөг буюу 74.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь хөрөнгийн зардлын 58.4 хувийн гүйцэтгэл нөлөөлсөн байна. Тайлант онд 13,020.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 94 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс 5,420.0 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор шинээр нэмж тодотгосонтой холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.27 “Орон нутгийн 2024 төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитаар Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.23, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.14, 3.2.2.15, 3.2.2.26 гэж заасантай нийцээгүй тул 1,200.0 сая төгрөгийн “кино павилон барих” төсөл, арга хэмжээг хасах санал хүргүүлснийг төсвийн төслөөс хасаагүйгээс төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

#### **БҮЛЭГ 4: АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦЭЛ 42,316.7 СЯА ТӨГРӨГИЙН АШИГТАЙ ГАРСАН БАЙНА**

4.1.1 Аймгийн нийт тэнцлийг 1,355.1 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 42,316.7 сая төгрөгийн ашигтай гарсан байна.

Хүснэгт 13. Нэгдсэн төсвийн тэнцэл (сая төгрөг)

Үзүүлэлт	2024 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>109,772.2</b>	<b>123,858.0</b>
Татварын орлого	60,794.6	73,580.8
Татварын бус орлого	4,665.2	6,704.5
Тусламжийн орлого	20,763.4	20,023.7
Өмнөх оны дансны үлдэгдэл	23,549.0	23,549.0
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	108,417.1	81,541.3
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>1,355.1</b>	<b>42,316.7</b>

4.1.2 Тайлант онд төсвийн нийт орлогоор 65,459.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 20,763.4 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 23,549.0 сая төгрөг, нийт 109,772.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

4.1.3 Гүйцэтгэлээр нийт 123,858.0 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, нийт зардал ба цэвэр зээлд 81,541.3 сая төгрөгийг зарцуулснаар нийт тэнцэл 42,316.7 сая төгрөгийн ашигтай илэрхийлэгдсэн байна.

4.1.4 Аймгийн ерөнхий орлогын данснаас сангийн яамнаас тайлант оны эцэст аймгийн давсан орлого болон төсвийн хэмнэлтээс “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн дамжуулан зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрт 18,250.0 сая төгрөгийг суутгасан байна.

<sup>3</sup> Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

<sup>4</sup> Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

<sup>5</sup> Эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

<sup>6</sup> Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

## ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Дархан-Уул аймгийн 2024 оны нэгдсэн төсөв нь төсвийн бодлогын зорилт, “Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө”-нд тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.
- Дархан-Уул аймгийг хөгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний 3 зорилт, арга хэмжээг орон нутгийн төсөвт батлаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.
- Төсвийн нийт орлого ба тусламжийн дүн өмнөх оны гүйцэтгэлээс 63.9 хувиар өсөж, орлогын гүйцэтгэл 112.8 хувиар, зарлагын гүйцэтгэл өнгөрсөн оны гүйцэтгэлээс 56.4 хувиар өсөж, 74.3 хувийн гүйцэтгэлтэй гарч, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 42,316.7 сая төгрөгийн ашигтай буюу эерэг үзүүлэлттэй байна.
- Аймгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 28,231.0 сая төгрөг буюу 74.3 хувьтай гарсан нь хөрөнгийн зардлын 58.4 хувийн гүйцэтгэл нөлөөлсөн байна
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн 13,020.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 94 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй бөгөөд үүнээс 4,970.4 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор шинээр нэмж төлөвлөснөөс шалтгаалжээ.
- Аймгийн ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс 512.5 сая төгрөгийн дэмжлэг олгосон нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 34 дүгээр зүйлийн 34.6, 34.6.3-т заасантай тус тус нийцэхгүй байна
- Сангийн яам аймгийн ерөнхий орлогын данснаас тайлант оны эцэст давсан орлого болон төсвийн хэмнэлтээс “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн дамжуулан зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрт 18,250.0 сая төгрөгийг суутгасан байна.

## ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагч Б.Азжаргалд зөвлөх нь:

- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний орон нутгийн төсвөөс хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг аймгийн жилийн төсөвт тусгаж, батлуулж байх
- Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 34 дүгээр зүйлийн 34.6.3 дахь заалтыг баримталж, аудитын тайлан хүргүүлсэн өдрөөс хойш орон нутгийн төсвөөс ИТХ-д суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгохгүй байх
- Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т заасны дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 05-ны дотор багтаан Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2025.04.18

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн ТЕЗ	3	512.5	-	-	-	-	3	512.5	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>512.5</b>	-	-	-	-	<b>3</b>	<b>512.5</b>	-	-	-	-



**Дархан-Уул аймгийн 2024 оны нэгтгэсэн төсвийн  
гүйцэтгэлийн тайлан**

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	109,772,304.9	81,541,297.4	(28,231,007.5)	74.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,060,939.5	55,994,315.6	(9,066,623.9)	86.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,867,365.9	39,975,347.8	(6,892,018.1)	85.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,894,776.0	13,009,423.6	(885,352.4)	93.6
210101	Үндсэн цалин	6,274,655.0	6,242,451.5	(32,203.5)	99.5
210102	Нэмэгдэл	5,329,930.1	4,546,658.7	(783,271.4)	85.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	518,770.7	640,645.5	121,874.8	123.5
210104	Урамшуулал	876,319.5	783,146.7	(93,172.8)	89.4
210105	Гэрээт ажлын хөлс	895,100.7	796,521.2	(98,579.5)	89.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,750,157.1	1,552,178.9	(197,978.2)	88.7
210201	Тэтгэврийн даатгал	1,191,285.4	1,063,945.8	(127,339.6)	89.3
210202	Тэтгэмжийн даатгал	139,717.8	128,336.4	(11,381.4)	91.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	69,859.1	67,555.8	(2,303.3)	96.7
210204	Ажилгүйдлийн даатгал	69,859.1	55,922.2	(13,936.9)	80.1
210205	Эрүүл мэндийн даатгал	279,435.7	236,418.7	(43,017.0)	84.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,171,648.4	6,635,693.2	(2,535,955.2)	72.4
210301	Гэрэл, цахилгаан	2,248,079.7	1,331,087.8	(916,991.9)	59.2
210302	Түлш, халаалт	5,199,115.5	3,949,589.0	(1,249,526.5)	76.0
210303	Цэвэр, бохир ус	1,564,270.8	1,201,688.5	(362,582.3)	76.8
210304	Байрны түрээс	160,182.4	153,327.9	(6,854.5)	95.7
2104	Хангамж, бараа материалын зардал	560,240.7	540,074.6	(20,166.1)	96.4
210401	Бичиг хэрэг	103,709.5	96,847.8	(6,861.7)	93.4
210402	Тээвэр, шатахуун	297,722.0	286,607.1	(11,114.9)	96.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	83,276.0	80,647.9	(2,628.1)	96.8
210404	Ном, хэвлэл	2,300.0	2,300.0	(0.0)	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,605.8	11,391.3	3,785.5	149.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	65,627.4	62,280.5	(3,346.9)	94.9
2105	Нормативт зардал	144,530.6	140,254.9	(4,275.7)	97.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,549.1	70,543.1	(6.0)	100.0
210502	Хоол, хүнс	48,800.0	48,792.9	(7.1)	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,181.5	20,918.9	(4,262.6)	83.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,856,257.5	2,711,949.3	(144,308.2)	94.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	727,419.5	634,767.2	(92,652.3)	87.3
210602	Тавилга	329,834.0	311,043.1	(18,790.9)	94.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,070.4	4,462.7	(1,607.7)	73.5
210604	Урсгал засвар	1,792,933.6	1,761,676.3	(31,257.3)	98.3
2107	Томиллолт, зочны зардал	188,292.1	173,333.5	(14,958.6)	92.1
210702	Дотоод албан томиллолт	188,292.1	173,333.5	(14,958.6)	92.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,904,867.6	8,896,063.3	(2,008,804.3)	81.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	10,812,180.9	8,847,308.1	(1,964,872.8)	81.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,428.9	7,268.4	(6,160.5)	54.1
210803	Даатгалын үйлчилгээ	11,557.4	8,756.3	(2,801.1)	75.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,318.7	1,661.4	(2,657.3)	38.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,134.0	539.0	(595.0)	47.5

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,851.2	17,433.0	(4,418.2)	79.8
210807	Газрын төлбөр	40,271.0	13,097.1	(27,173.9)	32.5
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	125.5	-	(125.5)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,396,595.9	6,316,376.4	(1,080,219.5)	85.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,335,519.1	6,263,457.9	(1,072,061.2)	85.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,076.8	52,918.5	(8,158.3)	86.6
211	ХҮҮ	3,600,000.0	3,600,000.0	-	100.0
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	3,600,000.0	3,600,000.0	-	100.0
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	3,600,000.0	3,600,000.0	-	100.0
212	ТАТААС	4,934,207.6	4,567,497.4	(366,710.2)	92.6
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,353,480.7	1,333,480.7	(20,000.0)	98.5
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,353,480.7	1,333,480.7	(20,000.0)	98.5
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,580,726.9	3,234,016.7	(346,710.2)	90.3
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,580,726.9	3,234,016.7	(346,710.2)	90.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,659,366.0	7,851,470.4	(1,807,895.6)	81.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	8,269,897.5	6,597,668.0	(1,672,229.5)	79.8
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	8,269,897.5	6,597,668.0	(1,672,229.5)	79.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,389,468.5	1,253,802.4	(135,666.1)	90.2
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	220,656.7	198,660.3	(21,996.4)	90.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	144,997.7	138,155.1	(6,842.6)	95.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,175.0	58,175.0	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	132,822.9	61,121.2	(71,701.7)	46.0
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	664,516.7	633,296.0	(31,220.7)	95.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	168,299.5	164,394.8	(3,904.7)	97.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,632,182.2	25,488,981.8	(18,143,200.4)	58.4
221001	Их засвар	3,760,132.9	1,437,773.7	(2,322,359.2)	38.2
223001	Бусад хөрөнгө	39,872,049.3	24,051,208.2	(15,820,841.1)	60.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,079,183.2	58,000.0	(1,021,183.2)	5.4
230001	Эргэж төлөгдөх зээл	1,079,183.2	58,000.0	(1,021,183.2)	5.4
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	109,772,304.9	86,246,535.8	(23,525,769.1)	78.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,413,377.2	20,023,660.8	(389,716.4)	98.1
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	20,413,377.2	20,023,660.8	(389,716.4)	98.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	72,206,893.6	64,943,636.7	(7,263,256.9)	89.9
320001	Орон нутгийн төсвөөс	71,856,822.8	64,943,636.7	(6,913,186.1)	90.4
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	350,070.8	-	(350,070.8)	-
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17,152,034.1	1,279,238.3	(15,872,795.8)	7.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,372,631.0	1,131,573.6	(241,057.4)	82.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	180,052.3	147,664.7	(32,387.6)	82.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	15,599,350.8	-	(15,599,350.8)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	4,709,877.7	4,709,877.7	-

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	6,338,767.8	6,338,767.8	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	40	40	0	100.0
610001	Төсвийн байгууллага	40	40	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	409	397	0	97.1
620001	Удирдах ажилтан	60	59	0	98.3
620002	Гүйцэтгэх ажилтан	265	247	0	93.2
620003	Үйлчлэх ажилтан	79	83	0	105.1
620004	Гэрээт ажилтан	5	8	0	160.0



**Нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,261,649.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,817,462.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,271,401.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,373.6
210101	Үндсэн цалин	42,948.3
210102	Нэмэгдэл	3,160.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,184.6
210104	Урамшуулал	7,080.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,470.1
210201	Тэтгэврийн даатгал	2,972.9
210202	Тэтгэмжийн даатгал	349.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	305.1
210204	Ажилгүйдлийн даатгал	174.9
210205	Эрүүл мэндийн даатгал	667.4
2104	Хангамж, бараа материалын зардал	28,061.5
210401	Бичиг хэрэг	3,552.5
210402	Тээвэр, шатахуун	21,002.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,310.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,196.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,162.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200.1
210602	Тавилга	12,640.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,322.0
210604	Урсгал засвар	10,000.0
2107	Томиллолт, зочны зардал	8,755.2
210702	Дотоод албан томиллолт	8,755.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	586,167.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	576,957.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,210.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	549,411.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	545,671.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,740.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	546,060.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,110.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,110.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	541,950.9
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	541,950.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	444,187.4
2200	Дотоод эх үүсвэрээр	444,187.4
223001	Бусад хөрөнгө	444,187.4
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,261,649.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,261,649.7
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	423,002.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,828,666.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,981.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-